

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ОНЦ ЧУХАЛ МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ
МЯГМАРЖАВ ОВОГТОЙ ОРОЛЗОДЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах”							
1.	Арга хэмжээ 1.1 Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөний төслийг үндэсний хэмжээний кибер халдлага, зөрчил үүссэн үед хариу арга хэмжээ авах тусгайлсан чиг үүргийн байгууллагуудтай хамтран боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр оролцогч талуудыг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналуудыг төлөвлөгөөний төсөлд тусгасан. Энэхүү төлөвлөгөө нь төрийн нууцад хамаарах тул хэлэлцүүлэгт оролцсон албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулсан. Тус яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв болон Нийтийн төвийн төлөөлөл оролцсон уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулж, эдгээр байгууллагуудтай зөвшилцөлд хүрсний үндсэн дээр төлөвлөгөөний төслийг эцэслэн	05-09	100

					боловсруулсан. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу тагнуулын байгууллагаас Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө болон Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар батлагдсан.		
2.	Арга хэмжээ 1.2. "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангуулах	Нийтлэг журамд нийцүүлэн кибер аюулгүй байдлыг хангах дотоод журамтай болсон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын тоо	-	40	"Эрүүл мэндийн байгууллагын кибер аюулгүй байдал" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудад кибер аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцэж, кибер аюулгүй байдлын тухай хууль, журмыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгсөн. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан албан хаагчид болон удирдлагуудад кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг мөрдөж ажиллах, байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах журам жишиг журам боловсруулж, хүргүүлж ажилласан. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын дунд хийсэн судалгаанд 88 байгууллага хамрагдсанаас 30 байгууллага кибер аюулгүй байдлыг хангах дотоод журмыг шинэчлэн баталсан, 28 байгууллага шинэчлэн боловсруулж байгаа бол нийт байгууллагуудын 67% нь "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.	05-12	100
3.	Арга хэмжээ 1.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын жагсаалтад өөрчлөлт оруулах санал боловсруулах	Засгийн газрын тогтоолын төслийн тоо			Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, жагсаалтыг шинэчлэх суурь судалгааны асуулгыг 3 бүлэг 93 асуулттайгаар боловсруулсан. Судалгааны асуулга бүхий вэб хуудсыг хөгжүүлж, судалгаа авах тухай 2024 оны 03/710 тоот албан бичгийг онц чухал мэдээллийн	07-12	100

					дэд бүтэцтэй байгууллагуудад хүргүүлж, судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад байгаа байгууллагуудын 77.5 хувь нь уг жагсаалтад багтах шаардлагатай гэж үзэж байгаа бол 22.5 хувь энэ жагсаалтаас хасуулах хүсэлтэй байсан. “Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 39 дүгээр тэмдэглэлийн 2 дахь заалтад онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг сайдад үүрэг болгосон. Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоол болон Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтын төслийг боловсруулж байна.		
4.	Арга хэмжээ 1.4. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын мэдээллийн систем, сүлжээ, мэдээллийн сангийн хамгаалалтыг сайжруулах, шинэчлэх бодлогын удирдамж, зөвлөмжөөр хангах	Зөвлөмж гаргасан эсэх Тийм-1, Үгүй-0	-	1	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан кибер халдлага зөрчилд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн систем, сүлжээний эмзэг байдал болон эрсдэлийг тодорхойлох ажлыг зохион байгуулсан. Ажлын хэсгээс Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, харьяа 5 байгууллага, Хас банк, Инвескор ХХК, Үндэсний дата төв УТҮГ, Соно Финтек ББСБ, И-Монгол Академи УТҮГ-т хяналт шалгалт хийсэн бөгөөд хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийг байгууллага бүрээр боловсруулж, Ажлын албанд хүргүүлсэн.	06-10	100
5.	Арга хэмжээ 1.5.	Журмын төслийн тоо	-		Байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах дотоод журмын төслийг Нийтлэг үндэслэл, Кибер	06-12	70

	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам боловсруулах				аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ, Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг тодорхойлох, Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, Кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах гэсэн бүлгийн хүрээнд боловсруулж байна.		
Зорилт 2. “ Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх”							
1.	Арга хэмжээ 2.1. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлэн ажилласан эсэх Тийм-1, Үгүй-0	-		Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын үйл ажиллагааны цар хүрээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Ухаалаг Засаг-2" төсөл, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран ажиллаж байна. Япон Улсын хөгжлийн албан ёсны тусламжийн суурь судалгааг 2025 оны 4-5 дугаар сард эхэлнэ. АНУ, Япон улсын хамтын ажиллагааны хүрээнд Нийтийн төвийн албан хаагчдыг кибер аюулгүй байдлын чиглэлийн сургалт, арга хэмжээнүүдэд тогтмол хамруулж, хүний нөөцийг чадавхжуулах дэмжлэг үзүүлсэн. Нийтийн төвийн гадаад хамтын ажиллагааг өргөтгөх хүрээнд Энэтхэг улсын элчин сайдын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "CERT-In" кибер аюулгүй байдлын төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар ажиллыг эхлүүлсэн. ОУЦХБ-тай хамтран Нийтийн төвийн үйл ажиллагааны төлөвшилийг тодорхойлох судалгааг эхлүүлэхээр ярианы түвшинд явагдаж байна. Мөн гадаад хамтын ажиллагааг өргөтгөх, сайд, төрийн нарийн бичгийн даргын гадаад уулзалтын ярианы сэдэвт нийтийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, чадавхжуулах талаар саналуудыг тусгаж ажилласан.	06-12	100
2.	Арга хэмжээ 2.2. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн ажиллах журмын төслийг боловсруулах	Журмын төслийн тоо	-	1	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-аас 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Нийтийн төвийн ажиллах журмын төсөл ирүүлснийг яамдаас санал авахаар ажиллаж байна.	06-12	30

Зорилт 3. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаатай төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулах”

1.	Арга хэмжээ 3.1. “iTactic” халдлага, зөрчлийн дадлага сургуулилтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	-	1	Кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх “ITACTIC-2” команд штабын хамтарсан сургуулилтыг 2024 оны 12 дугаар сарын 12-ноос 13-ны өдрүүдэд кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулагдах бөгөөд гадаад албан томилолттой байгаа тул зохион байгуулалтад оролцох боломжгүй болсон. Бруней улсад зохион байгуулагдсан “Ази номхон далайн бүс нутгийн кибер дадлага сургуулилт-2024” арга хэмжээнд Монгол Улсын кибер аюулгүй байдлын туршлагаас солилцож оролцсон. ОУЦХБ-тай хамтран “Ази номхон далайн бүс нутгийн кибер дадлага сургуулилт-2025” арга хэмжээг өөрийн улсдаа зохион байгуулах боломжийг судлах, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	05-12	20
----	---	---	---	---	---	-------	----

Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

1.	Арга хэмжээ 4.1. Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнана.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо		ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, гүйцэтгэлийн тайланг заасан хугацаанд гаргасан.	05-12	100
2.	Арга хэмжээ 4.2. Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллана.	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх		Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагна	Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэж, тайлагнаж ажилласан.	05-12	100

				сан байна.			
3.	Арга хэмжээ 4.3. Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх		Хэрэгжилт тээр	Кибер аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг тухай бүр, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр гаргаж, ТЗУГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд кибер аюулгүй байдлыг хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, тоон гарын үсгийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой арга хэмжээнүүдийг төлөвлөж, БТГ-т хүргүүлсэн. Мөн кибер аюулгүй байдлыг хангах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдийг тухай бүр боловсруулж, БТГ, ГХАХ-т хүргүүлж ажилласан.	05-12	100
4.	Арга хэмжээ 4.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлнэ.	Хууль болон холбогдох журамд нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж үүсгэсэн эсэх		Хэрэгжилт тээр	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох журмын дагуу албан бичгийн төсөл, захиргааны хэмжээний актын төслийг боловсруулж, албан бичгүүдийг шийдвэрлэж ажилласан.	05-12	100
5.	Арга хэмжээ 4.5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо	-	Хэрэгжилт тээр	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай холбоотой 2 өргөдөл цохогдож ирсэн. Өргөдлийг шийдвэрлэхтэй холбоотойгоор Үндэсний дата төв УТҮГ болон Хил хамгаалах ерөнхий газруудаас тодруулга авч, мэдээллийн дагуу өргөдлүүдийг шийдвэрлэж хариуг цахим болон албан бичгээр хүргүүлж ажилласан.	05 -12	100

	хугацаанд нь шийдвэрлэн ажиллана.						
6.	Арга хэмжээ 4.6. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг ханган ажиллана.	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо	-	Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо - 1	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг албан тушаалд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор цахим хэлбэрээр гаргаж, байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан хаагчид баталгааны маягтыг хүргүүлсэн.	05	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааг зохион байгуулах	Судалгаа хийгдсэн эсэх Тийм-1, Үгүй-0	-	1	Тус яам Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Английн Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын төвтэй хамтран Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх, зорилтот түвшинг тодорхойлох судалгааг 2024 оны 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Кибер аюулгүй байдлын чадавхын төвийн судлаачид кибер аюулгүй байдлын чадавхыг а) кибер аюулгүй байдлын бодлого ба стратеги, б) кибер аюулгүй байдлын соёл ба нийгэм, в) кибер аюулгүй байдлын мэдлэг ур чадварыг хөгжүүлэх, г) хууль эрх зүйн орчин, д) стандарт ба технологи гэсэн сэдвийн хүрээнд зөвлөлдөх уулзалтыг удирдан явуулсан бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн 80	08-12	100

					байгууллагын 110 орчим ажилтан, албан хаагчид оролцсон. Бэлтгэл ажлын хүрээнд судалгаанд оролцогч байгууллагуудыг тодорхойлох, урилга хүргүүлэх, оролцогчдын жагсаалт, танилцуулга хөтөлбөрийг монгол, англи хэл дээр боловсруулж, зохион байгуулалтыг хангаж ажилласан. Мөн Судалгааны багийн гишүүд, ИБУИНХУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Фиона Блайт болон ЦХИХХЯ-ны сайдын уулзалтыг ГХХ-тэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Судалгаан тайлангийн төслийн хувилбар 2024 оны 12 дугаар сарын 23-нд бэлэн болох бөгөөд тайланд ашигласан мэдээллийн үнэн зөвийг хянан шалгах ажлыг зохион байгуулахаар бэлтгэж байна.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилтийг зохион байгуулах	Стандартын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах	-	Стандартын төсөл	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар теле хяналтын камерын стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, теле хяналтын камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 4, 28-ны өдрүүдэд хуралдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Теле хяналтын системийн техникийн шаардлага MNS 6423:2019 стандартыг судалж, тээврийн хэрэгслийн дүрс бичлэгийн камер болон цагдаагийн энгэрийн камер, түүнд тавигдах шаардлагуудыг хариуцсан чиглэлийн дагуу боловсруулж, стандартын төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Мөн Аймаг, Дүүргийн Засаг даргын дэргэд байгуулагдах теле хяналтын нэгдсэн төв болон дэд төвүүд теле хяналтын камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна.	10-12	90

3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Виртуал бүсийн зөвлөлийн ажиллах журмын төсөл боловсруулах	Засгийн газрын тогтоолын төслийн тоо	-	1	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар байгуулагдсан “Виртуал бүсийн Зөвлөлийн ажиллах журам болон виртуал бүсийн ажиллах журмын төслүүдийг боловсруулах” ажлын хэсэгт ажиллаж, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.2-т заасан Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн ажиллах журмын төслийг ажлын хэсгийн гишүүдтэй хамтран боловсруулж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Тогтоолын төслийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 97 дугаар тогтоолоор баталсан.	07-09	100
----	--	--------------------------------------	---	---	--	-------	-----

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Кибер аюулгүй байдлын засаглал ба аудит сургалтад хамрагдах	Гэрчилгээний тоо	0	1	Кибер аюулгүй байдлын засаглал ба аудит сэдэвт сургалтад 2024 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд хамрагдаж, 24-ний өдөр сурсан мэдлэгээр сургалт хийснээр “сургагч багш” гэрчилгээг авсан.	05	100
2.	Арга хэмжээ 2. Кибер дэх эмэгтэйчүүд сургалт, уулзалтад хамрагдах	Сургалтад бүрэн хамрагдсан эсэх	0	1	Кибер дэх эмэгтэйчүүд хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 07 дугаар сарын 8-12-ны өдрүүд, 12 дугаар сарын 2-6-ны өдрүүдэд кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллаж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалт, хуралд хамрагдсан.	07, 12	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах шинжээч

М.Оролзод / /

.....